



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2019. 02.22 № 07

Асуулга тавих тухай

Уул уурхайн салбар нь Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбар бөгөөд 2018 оны жилийн эцсийн байдлаар улсын тесөвт 2 их наяд 51,5 тэрбум төгрөгийн татвар, хураамжийг төвлөрүүлснээс нүүрс 910,6 тэрбум төгрөг, зэс 871,9 тэрбум төгрөг, алт 80,0 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлээд байна.

Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 456,3 тэрбум төгрөгөөр буюу 28,6 хувиар өссөн дүн бөгөөд улсын экспорт 7 тэрбум 11,8 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 811,1 сая ам.доллараар буюу 1,1 дахин өссөн байна.

Монгол Улсын төсвийн сахилга бат сайжирч, өрийн дарамт буурч, уул уурхай, эрдэс баялгийн салбар өсөлттэй байгаа энэ үед эдийн засгийн өсөлтөд түлхэц үзүүлж чадах ашигт малтмалын томоохон ордуудаа Улсын Их Хурал, Засгийн газрын зүгээс онцгойлон анхаарч ажиллах шаардлагатай байна.

Зайлшгүй анхаарах шаардлагатай Өмнөговь аймагт орших Хармагтайн орд нь нөөцөөрөө дэлхийд томоохонд тооцогдох бөгөөд хоёр дахь Оюу толгой гэж нэрлэгдсэн тус орд алт, зэсийн баялаг нөөцтэй болох нь тогтоогдсон билээ. Тус орд 680 мянган тонн зэс, 70 тонн алтны нөөцтэй гэгдэж байсан бол 2018 онд зэсийн агууламж 400 хувь, алтны агууламж 249 хувиар нэмэгдэж 1,9 сая тонн зэс, 4,3 сая унци алтны нөөцтэй гэсэн албан бус мэдээлэл цацагдаж иргэдээс тус ордтой холбоотой албан ёсны мэдээллийг шаардах боллоо.

Хармагтайн орд нь Улсын Их Хурлын 2007 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн "Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай" 27 дугаар тогтоолд хамаардаггүйгээс Улсын Их Хурал Ашигт малтмалын тухай хуульд заасан тодорхой эрх, үүргээ хэрэгжүүлж чадалгүй өнөөдрийг хүрсэн байна. Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасан Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Танд хандан тавьж байна. Үүнд:

- Хармагтайн ордыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаарх мэдээллийг анхны тусгай зөвшөөрөл эзэмшигчээс эхэлж, ямар шийдвэрээр олгогдсон байдлаар;
- Тус ордын геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажил ямар санхүүжилтээр хэрхэн хийгдсэн талаар;


3. Тус ордын геологийн нөөц буюу урьдчилсан техник, эдийн засгийн үнэлгээ, үйлдвэрлэлийн нөөц буюу техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн талаар;

4. Засгийн газраас тус ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, эзэмшилийн хувь хэмжээг тогтоох, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах талаар ямар бодлого баримтлан, хэрхэн ажиллаж байгаа талаар.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонсгохыг Танаас хүсье.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



ТАЮУРСАЙХАН